



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН


МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№156 /370/

2022.09.05

Цаг үе, үйл явдал

БНЭУ-ЫН БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД РАЖНАТ СИНГХ МОНГОЛ УЛСАД АЙЛЧИЛНА



Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярын урилгаар энэ сарын 5-наас 7-ны өдрүүдэд БНЭУ-ын Батлан хамгаалахын сайд Ражнат Сингх Монгол улсад албан ёсны айлчлал хийх гэж байна. БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг, БНЭУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд М.П.Сингх, БХЯ-ны ГХАГ-ын дарга хурандаа Б.Бат-Эрдэнэ, БНЭУ-аас Монгол улсад хавсран суугаа Батлан хамгаалахын атташе хурандаа Ж.Вишал тэргүүтэй бүрэлдэхүүн БНЭУ-ын Батлан хамгаалахын сайд Ражнат Сингхийг өнөө орой “Чингис Хаан” олон улсын нисэх буудалд угтан авах юм.

ЦЭРГИЙН ГЭРЭЭТ АЛБЫГ СУРТАЛЧИЛЛАА



Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчдад “Гэрээт цэрэг-Гэрэлтэй алба” сурталчилгааны арга хэмжээг Зэвсэгт хүчний 330 дугаар ангиас зохион байгууллаа. Энэ өдөрлөгөөр тус ангийн хошууч Х.Мөнхбаяр, ахмад Т.Даваацэрэн нар цэргийн гэрээт албаны эрх зүйн орчин, нийгэм хамгаалал, сургалт, дамжаа зэрэг олон талын мэдээлэл өгч имсонирхсон асуултад нь хариулсан юм. Ялангуяа “Цэргийн гэрээт алба хаах журам”-д заасанчлан тэргүүний цэргийн гэрээт алба хаагчид их дээд сургууль, дотоод сургалт дамжаанд суралцаж, мэргэжил эзэмших, энхийг сахиулах ажиллагаа, бүтээн байгуулалтын ажилд оролцох боломж байдгийг онцлоод хугацаат цэргийн албанаас цэргийн гэрээт албанд элсэх хүсэлтэй түүрүүч, байлдагч нарыг бүртгэсэн юм.

Зэвсэгт хүчний 186 дугаар анги Ахмад Э.Ариунтуяа

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 12	☁️ 1


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 31	☁️ 23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.230	3.240
EUR 🇪🇺	3.235	3.270
CNY 🇨🇳	469	471
RUB 🇷🇺	50.40	51
JPY 🇯🇵	23.20	23.70
KRW 🇰🇷	2.36	2.39

ЗУРХАЙ



2022.09.05 /ДАВАА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 2

НАМРЫН ТЭРГҮҮН ШАР БИЧ САРЫН ДОЛООН УЛААН ЦАГААГЧИН ТАХИА ӨДӨР

Үс засуулбал:

Эрч хүч ихэснэ.

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
06.15-19.27

Барилдлага:

Рашаан

Шүтэн барилдлага:

Нэр өнгө

Суудал: Уул

Энэ өдөр үхэр, могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн.

Эл өдөр эм эмнэлгийн элдэв, үйл хагалгаа хийлгэх, биеийн тамирыг сэргээх, гаригийг тахиx, буг дарах, газрын ам бооход сайн. Улаа гаргах, хиншүү хярвас гаргах, мод суулгах, нарийн зөвлөгөөн хийх, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу.

Хол газраар яваар одогсод баруун хойд зүгт мөрөө гаргавал зохистой.



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 610,387,778

Эдгэрсэн

Нийт: 587,298,760

Нас барсан

Нийт: 6,504,025

Цаг үе, үйл явдал

ГОВЬД “ЭКО-НОГООН ХОТХОН” ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА



Байлдааны гавьяаны Улаантугийн одонт, жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит Зэвсэгт хүчний 336 дугаар ангийнхан Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, Батлан хамгаалах салбараас хэрэгжүүлж байгаа “Эко-Ногоон хотхон” төслийн хүрээнд шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Ялангуяа, ангийн орчин тойрны ногоон байгууламжийг сэргээн сайжруулж цэцэрлэгжүүлэх, мод, бут, зүлэг тарих, усалгааны систем хийх зэргээр цогц ажлыг гүйцэтгэж байгаа юм. Ангийн байрлалд монос 200, буйлс 200, далан хальс 200, нарс 20, шинэс 20, хайлаас 2400, улиас 300, голт бор 250, шар хуайс 1000, өрөл 250

гэхчлэн 10 төрлийн 5000 орчим мод, бутыг үрслүүлэн суулгаж, усалгааны 4 цэгийг төхөөрөмжлөн байгуулж, ногоон байгууламжийг усан ургуулах, арчлан хамгаалах ажлыг өөрсдийн хүч бололцоогоор гүйцэтгэсээр байна. Мөн ангийн гадна байрлалд 1000 улаан сухай, 300 загийн үрийг суулгаж, говь нутаг дахь ногоон байгууламжийг

нэмэгдүүлэхийн зэрэгцээ ангийн эмэгтэйчүүдийн зөвлөлөөс цэцгийн мандлыг арчлан ургуулж, бие бүрэлдэхүүнийхээ ажиллаж амьдрах таатай орчныг бүрдүүлсээр байгаа юм.

Ахлах дэслэгч А.Алтанхуяг (Зэвсэгт хүчний 336 дугаар анги)



Фото агшин



ТОРГОН ЦЭРЭГ ӨДГӨӨ СОНСОГЧ БОЛЖЭЭ

Өдгөөгөөс гурван жилийн өмнө Зэвсэгт хүчний 032 дугаар ангид хугацаат цэргийн алба хааж явсан байлдагч Г.Аригбөх ОХУ-ын Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр ийнхүү тэсвэр хатуужил зааж зогсох нь “Монцамэ” агентлагийн нэрт гэрэл зурагчин Б.Чадраабалын дуранд буусан байдаг юм.

Энэхүү зургаараа сошиалаар “од” болж байсан хугацаат цэргийн алба хаагч маань өдгөө өөрийн хүсэл мөрөөдлөө даган ОХУ-ын Цэргийн дээд сургуульд суралцаж байна.



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХУЯГ



ЦАХИМ ХАЯГ

Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб



ЦАХИМ ХУУДАС

“Соёмбо” сонин
“Дуулга” студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018

Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)